

“БҮРЭН ФИНАНС ББСБ” ХХК-ИЙН ОРОЛЦОГЧ

ТАЛУУДАЙ ХАРИЛЦАХ, ХАМТРАН АЖИЛЛАХ ХӨТӨЛБӨР

Нэг. Зорилго

1.1 Энэхүү хөтөлбөрийн зорилго нь Компанийн үйл ажиллагаанд ТУЗ болон Гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлэх, компанийн тогтвортой өсөлтийг хангах, үнэ цэнийг бий болгох, стратеги төлөвлөгөө хэрэгжүүлэх, компанийн хөрөнгө оруулагчдыг нэмэгдүүлэх, оруулсан хөрөнгийг хамгаалах, компанийн үйл ажиллагаанд хөрөнгө оруулагчдын оролцоог хангах, санал хүсэлтийг хүлээн авах, харилцан мэдээлэл солилцох, өөрийн бизнес, засаглал санхүүгийн үзүүлэлтүүд болон хэтийн төлөвийн талаарх бодит мэдээллийг хүргэхэд оршино.

Хоёр. Баримтлах зарчим

2.1 Компанийн засаглалын үр ашиг бүхий тогтолцооны үндсийг бүрдүүлэх: Компанийн засаглалын үндсэн тогтолцоо нь эдийн засагт үзүүлэх нөлөө, зах зээлийн бүрэн бүтэн байдлыг дэмжсэн үр ашигтай, шударга байх ёстой. Энэ нь хууль дүрэмтэй нийцэж, үр дүнтэй хяналт шалгалт хийх, хэрэгжүүлэх боломжийг хангасан байна.

2.2 Хувьцаа эзэмшигчдийн эрх, бүх хувьцаа эзэмшигчдэд адил, тэгш хандах ба өмчлөлийн үндсэн чиг үүрэг: Компанийн засаглалын тогтолцоо нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах болон эрхээ эдлэхэд нь туслалцаа үзүүлээд зогсохгүй, цөөнх хувьцаа эзэмшигчдийг ялгаварлахгүй адил хандах нөхцлийг бүрдүүлсэн байх.

2.3 Мэргэжлийн хөрөнгө оруулагч, үнэт цаасны зах зээл болон бусад зуучлагч: Компанийн засаглалын тогтолцоо нь хөрөнгө оруулалтын гинжин хэлхээний туршид зохистой хөшүүрэг үзүүлж, үнэт цаасны зах зээлийг компанийн сайн засаглалд хувь нэмэр оруулахуйц байдлаар үйл ажиллагаа явуулах нөхцлийг бүрдүүлэх.

2.4 Компанийн засаглалд оролцогч талуудын үүрэг: Компанийн засаглалын тогтолцоо нь оролцогч талууд болох хувьцаа эзэмшигчид, ажилчид, зээлдүүлэгчид, үйлчлүүлэгчид, нийлүүлэгчид болон бусад оролцогч талуудын эрхийг хууль тогтоомж, хамтын гэрээ хэлэлцээрийн дагуу хүлээн зөвшөөрөх, хүндэтгэх, компанийн санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн бодлого, мэдээллээр цаг тухай бүр хангаж оролцогч талуудын хоорондын идэвхтэй хамтын ажиллагааг дэмжихэд чиглэнэ.

2.5 Мэдээллийн нээлттэй, ил тод байдал: Компанийн засаглалын тогтолцоо нь компанийн санхүүгийн байдал, үйл ажиллагаа, өмчлөл болон засаглалтай холбоотой бүхий л мэдээллүүд нь хөрөнгө оруулагчийн шийдвэр гаргах чухал мэдээллүүд байдаг тул мэдээллийг цаг тухайд нь үнэн зөв, нийтэд нээлттэй байлгах боломжоор хангадаг. Мэдээлэл ил тод байснаар компаниуд хөрөнгө татах болон зах зээл дээр илүү итгэлцлийг бий болгох боломжийг бүрдүүлэх. Санхүүгийн тайланг хөндлөнгийн, мэргэжлийн аудитын байгууллагаар баталгаажуулж байх.

Гурав. Компанийн тогтвортой өсөлтийг хангах

3.1 Компанийн тогтвортой өсөлтийг хангах чиглэлээр дараах үйл ажиллагааг компани нь үйл ажиллагаандаа хэрэгжүүлнэ. Үүнд: